



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

341.	Засгийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагнах тухай	Дугаар 213	1285
342.	Журамд нэмэлт оруулах тухай	Дугаар 214	1287

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 7 дугаар  
сарын 2-ны өдөр

Дугаар 213

Улаанбаатар  
хот

#### **Засгийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагнах тухай**

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Их Монгол Улсын 808 жилийн ой, Ардын хувьсгалын 93 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан дор дурдсан хүмүүсийг Монгол Улсын Засгийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагнасугай:

Л.Гансүх	-Ерөнхий сайдын ахлах зөвлөх
Ш.Оюунчимэг	-Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн улсын ахлах байцаагч;
Н.Буяндэлгэр	-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахлах референт;
Б.Оюунцэцэг	-Хөвсгөл аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний албаны “Цагаан-Уул” харуулын ажиглагч;



Бит Кехрер	-Швейцарийн Холбооны Улсын иргэн, доктор;
Ц.Ариунсанаа	-Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга;
Ж.Баярцэцэг	-Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
О.Нямхүү	-Барилга, хот байгуулалтын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн;
Л.Ганхуяг	-Монгол цэргийн музейн ерөнхий нягтлан бодогч;
Д.Адьяасүрэн	-Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Боловсролын хэлтсийн дарга;
Ж.Батболд	-Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн;
С.Батцэцэг	-Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн;
Б.Нэргүй	-Уул уурхайн яамны Уул уурхайн бодлогын хэлтсийн дарга;
У.Сауле	-Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Хяналт-Шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга;
С.Жамьянсүрэн	-Хөдөлмөрийн яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Ажиллах хүчний шилжих хөдөлгөөний хэлтсийн дарга;



- Л.Мөнхзул -Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
- Г.Батхүрэл -Эдийн засгийн хөгжлийн яамны Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлт, зохицуулалтын газрын орлогч дарга;
- С.Баярбат -Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга;
- Д.Амар -Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Ч.САЙХАНБИЛЭГ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 7 дугаар  
сарын 4-ний өдөр

Дугаар 214

Улаанбаатар  
хот

### **Журамд нэмэлт оруулах тухай**

Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8.1, 8.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

“Журам, чиглэл шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2014 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”-ын 2 дугаар зүйлд дараах заалтыг нэмсүгэй:



“2.2.3 Хичээлийн жилийн өмнөх улирлын голч дүн нь 2.0-оос доошгүй үнэлэгдсэн байх.”

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД**

**Л.ГАНТӨМӨР**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 0.25

**Индекс: 14003**